

# Буцаж ирсэн хүү

-The Prodigal Son-



68Page

**Тайлбарлагч** Сайхан сэтгэлтэй баян эр амьдардаг байлаа. Тэр хоёр хүүтэй бөгөөд тэднийгээ хэн хүнээс ч илүү хайрладаг байлаа. Том хүү нь маш даруу аавынхаа үгэнд сайн ордог. Бага хүү нь наргиан наадамд дуртай дүрсгүй нэгэн байв. Бага хүү нь үргэлж гэрээсэв явж тусдаа амьдрахыг хүсдэг байлаа. Холын аялалд гарч дураараа наргиж цэнгэх нь түүний чин хүсэл мөрөөдөл байв.

**Бага хүү** Ааваа, надад өгөх гэж байсан эд хөрөнгөө урьдчилалд өгчих! Би гэрээсээ хол амьдармаар байна!

**Аав** Хүү минь, ингэж болдоггүй юм. Энэ дэлхий дээр амьдрах үнэхээр хэцүү. Жаахан л тэвччих.

**Бага хүү** Ааваа, би чинь нас биенд хүрсэн хүн! Би ганцаараа ч амьдарч чадна!

**Тайлбарлагч** Аавд нь бага хүүгээ явуулах сэтгэл байгаагүй боловч хүү нь явахыг маш их хүсэж байсан учир хөрөнгөнөөсөө хуваан өгч үлдж мордуулав.

**Тайлбарлагч** Бага хүү нь холын оронд очиж, хотын гоё чамин зүйлд татагдаж мөнгөө дураараа үрж эхлэв. Өдөр болгон наргин зугаацаж ажил хийсэнгүй.

**Бага хүү** Эртнээс ингэж амьдрах байсан юм. Өөрийнхөө дураар амьдрах сайхан юмаа. Үнэхээр сайхан.

**Тайлбарлагч** Шөнө бүр найр хийж, шинэ найзуудаа дуудан амттай хоол идэж, дарс уудаг байв. Тэгээд болоогүй хаан хүн шиг үнэтэй хувцас өмсөж, эрдэнийн чулуугаар өөрийгөө гоёв. Эцэст нь эцгээсээ авсан бүх хөрөнгө мөнгө нь дуусаж орхив.

**Тайлбарлагч** Мөнгө дуусмагц, түүний хажууд байсан найзууд ч мөн холдон явцгаав. Бага хүү юу ч үгүй хоосон, бас ганцаараа үлдэх нь тэр. Гэдэс нь ихэд өлсөж тэсэж чадахгүй нэгэн айлд зарцаар ажилд оров. Эзэн нь түүнд ингэж хэлэв.

**Эзэн** За нааш хар. Энэ гахайн хороог сайтар цэвэрлэх хэрэгтэй. Гахайнуудыг цаг цагт нь хооллолхоо мартваа



69Page



70Page

**Бага хүү** Аа, гахайнуудын хоолноос болтугай гэдэсээ цадгал идмээр байна. Ий ий ий

**Тайлбарлагч** Бага хүү үнэхээр их өлсөж, зовсон учир гунигтай байлаа. Тэр үед аавыгаа ихэд санав.

**Бага хүү** Аав минь намайг үнэхээр их хайрладаг байжээ. Аавын минь гэрт тэр олон зарц нар бүгд цатгалан сайхан амьдарч байхад би энд өлсөж үхэхнээ. Эцэг дээрээ буцан очиж уучлалт гуйгаад намайг зарцаа ч хамаагүй болгооч гэж гуйя даа.



71Page

**Тайлбарлагч** Бага хүү холын орныг орхин төрсөн нутаг руугаа буцаж явахаар болжээ. Төрсөн нутаг, гэр нь ойртох тусам тэрний сэтгэл догдлон түгшиж эхлэв.

**Бага хүү** Эцэг минь миний гэм бурууг уучлах болов уу? Би аавынхаа өгсөн бүх мөнгийг үрэн таран хийгээд гуйлгачин болоод ирж байгаа юм чинь аав ч намайг уучлахгүй байх даа. Иийний

**Тайлбарлагч** Бага хүү нь уйлан уйлсаар төрсөн нутаг руугаа явав. Гэтэл гэрийнхээ үүдэнд зогсож байгаа аавыгаа харлаа. Тэр бага хүүгээ буцаад ирэх байх гээд өдөр бүр үүдэндээ харуулдан зогсдог байсан нь энэ байж. Холоос ядарч гундсан бага хүүгээ ирэхийг хараад гүйн очиж тэврэн авчээ.

**Бага хүү** Ааваа, би үнэхээр буруу юм хийжээ. Одоо намайг хүүгээ гэж битгий дууд, боол зарцаа болгож дуудна уу.

**Аав** Юу гэсэн үг вэ? хүү минь, би өдөр бүр чамайг хүлээсэн. Чамайг бүх эд хөрөнгөө аван гэрээсээ явахад ч чамд хайртай хэвээрээ байсан, одоо ч чамайг хайрласан хэвээрээ. Чи бол миний хүү шүү дээ.



72Page

**Тайлбарлагч** Эцэг нь зарц нартаа ингэж хэлэв.

**Аав** Миний хүүд сайн хувцас өмсүүлж гарт нь бөгж зүүж, шинэ гутал өмсгө” тэгээд тарган тугал гарга. Алдаад буцаад олдсон хүү минь ирлээ.

**Тайлбарлагч** Эцэг нь их найр хийж бүгд хөгжилдөцгөөв. Бага хүү өөрт нь хандсан эцэгийн агуу хайрыг энэ үед л ухаарж гэнээ.



73Page